БАТЛАВ.
ЭРҮҮЛ МЭНДИЙН САЙД
Э.БАТШУГАР

# ЭРҮҮЛ МЭНДИЙН САЛБАРЫН АВЛИГЫН ЭСРЭГ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТӨЛӨВЛӨГӨӨ – 2026 ОН

2026 оны 04 дүгээр сарын 06-ны өдөр Улаанбаатар хот

| № | Хэрэгжүүлэх арга хэмжээ | Гүйцэтгэлийн шалгуур үзүүлэлт | Зорилтот түвшин | Хэрэгжүүлэх хугацаа |
|---|---|---|---|---|
| 1. | Олон нийтэд нээлттэй, ил тод болгохоор заасан мэдээллийг тухай бүр цахим системд нээлттэй байршуулж, үнэлгээ хийж олон нийтэд ил тод мэдээлнэ. | Олон нийтэд нээлттэй, ил тод болгохоор заасан мэдээллийг тухай бүр цахим системд нээлттэй байршуулсан тоо | Нээлттэй болгохоор хууль, журамд заасан мэдээллийг цахим системд байршуулсан байна. | 2026.04.10-2026.12.01 |
| 2. | Шүгэл үлээхийг дэмжих зорилгоор мэдээлэл өгөх суваг, хамгаалалтын арга хэлбэр, ач холбогдлын талаар эрүүл мэндийн ажилтнуудад сурталчилна. | Шүгэл үлээхийг дэмжих зорилгоор мэдээлэл өгөх суваг, хамгаалалтын арга хэлбэр, ач холбогдлын талаар сурталчилсан хэлбэр, тоо | Сурталчилгаа явуулсан байна. | 2026.04.10-2026.12.01 |
| 3. | Салбарын хэмжээнд сул орон тоонд хуулийн дагуу нээлттэй сонгон шалгаруулалт зарлах, хууль бус "түр орлон гүйцэтгэгч" томилохыг зогсоох | Холбогдох хууль, журмын дагуу хийсэн томилгооны тоо | Холбогдох хууль, журмын дагуу томилгоо хийсэн байна. | 2026.04.10-2026.12.01 |
| 4. | Нийтийн албанд томилогдохоор нэр дэвшсэн этгээд бүрийн хувийн ашиг сонирхлын мэдүүлгийг АТГ-аар хянуулж, дүгнэлт гарсаны дараа томилгоог баталгаажуулах | АТГ-ын хяналтад хамрагдсан томилгооны хувь | Тухай бүр АТГ-т ХАСУМ-ийг хянуулсан байна. | 2026.04.10-2026.12.01 |

| № | Хэрэгжүүлэх арга хэмжээ | Гүйцэтгэлийн шалгуур үзүүлэлт | Зорилтот түвшин | Хэрэгжүүлэх хугацаа |
|---|---|---|---|---|
| 5. | Эмч, эмнэлгийн мэргэжилтнүүд өөрийн болон хамаарал бүхий этгээдийн байгууллага руу өвчтөнийг чиглүүлэх үйл ажиллагаанд ёс зүйн хяналт тавих | Хяналт хийсэн тайлан | Хяналтаар гарсан зөрчлийг арилгасан байна. | 2026.04.10-2026.12.01 |
| 6. | Ажилчдын шагнал, урамшууллыг бэлнээр эргүүлэн татах, зориулалтын бусаар (ойн баяр гэх мэт) зарцуулахыг таслан зогсоох, санхүүгийн дотоод хяналтыг сайжруулах | Эрх бүхий байгууллагын дүгнэлтээр илэрсэн санхүүгийн зөрчлийн дүгнэлт | Зөрчлийг бүрэн арилгасан байна. | 2026.04.10-2026.12.01 |
| 7. | Салбарын удирдах ажилтан болон эмнэлгийн мэргэжилтнүүдэд Авлига, ашиг сонирхлын гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх чиглэлээр тогтмол сургалт зохион байгуулах | - Сургалтад хамрагдсан нийт ажилчдын эзлэх хувь<br>- Зохион байгуулсан сургалтын тоо | - ЭМЯ-ны харьяа байгууллагууд улиралд 1 сургалт зохион байгуулсан байх<br>Ажилтнуудын оролцоо 90%-с дээш байх | 2026.04.10-2026.12.01 |
| 8. | Байгууллага бүр төсвийн зарцуулалт, худалдан авах ажиллагаа, тендерийн мэдээллийг Шилэн дансны тухай хуулийн дагуу цаг тухайд нь мэдээлэх | Шилэн дансны хөтлөлтийн үнэлгээний хувь | Үнэлгээний хувь 95%-с дээш байх | 2026.04.10-2026.12.01 |
| 9. | Эрүүл мэндийн салбарын шударга байдлын үнэлгээг 2026 онд сайжруулах арга хэмжээний төлөвлөгөөг хэрэгжүүлэх | Төлөвлөсөн арга хэмжээний хэрэгжилтийн хувь | Төлөвлөгөөний хэрэгжилт 95%-с дээш байна. | 2026.04.10-2026.12.01 |
| 10. | Авлигатай тэмцэх газраас хүргүүлсэн зөвлөмж, дүгнэлтэд тусгагдсан зөрчлийг арилгах төлөвлөгөөг тухай бүр гарган, хэрэгжилтийг бүрэн хангаж, тайланг Авлигатай тэмцэх газар болон Эрүүл мэндийн яаманд хүргүүлэх | Ирүүлсэн зөвлөмж, дүгнэлтийн дагуу арилгасан зөрчлийн тоо | Зөвлөмжөөр өгсөн арга хэмжээ бүрэн хэрэгжсэн байх | 2026.04.10-2026.12.01 |
| 11. | Эрүүл мэндийн байгууллагад үйлчлүүлэгч төвтэй, хүндэтгэлтэй харилцаа, ёс зүйд суурилсан чанартай тусламж, үйлчилгээний соёлыг төлөвшүүлэх хүрээнд "Хүндэтгэлтэй | - Улирал бүр аян зохион байгуулсан харьяа байгууллагын тоо<br>- Ажилтнуудын оролцооны хувь | - ЭМЯ-ны харьяа байгууллагууд улиралд 1 аян зохион байгуулсан байх | 2026.04.10-2026.12.01 |

| № | Хэрэгжүүлэх арга хэмжээ | Гүйцэтгэлийн шалгуур үзүүлэлт | Зорилтот түвшин | Хэрэгжүүлэх хугацаа |
|---|---|---|---|---|
| | харилцаа – Чанартай тусламж” аян зохион байгуулах | | - Ажилтнуудын оролцоо 90%-с дээш байх | |
| 12. | Авлига, ёс зүйн зөрчлийн талаарх гомдол, мэдээллийг хүлээн авах олон сувгийн (утас, цахим, саналын хайрцаг) тогтолцоог бүрдүүлж, мэдээлэгчийн нууцлалыг ханган, шуурхай шийдвэрлэх үйл ажиллагааг зохион байгуулах | - Ажиллаж буй гомдол хүлээн авах сувгийн тоо (утас, цахим хайрцаг гэх мэт)<br>- Ирсэн гомдол, мэдээллийн шийдвэрлэлтийн хувь | - Доод тал нь 2 төрлийн суваг тогтмол ажилладаг байх<br>- Ирсэн гомдлын 90%-с дээш хувийг шийдвэрлэсэн байх | 2026.04.10-2026.12.01 |